

**ЗАВХАН АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН
ДЭС ТҮШМЭЛИЙН АНГИЛЛЫН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛЫН АЖЛЫН БАЙРНЫ
СУЛ ОРОН ТООГ НӨХӨХ ИРГЭДИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТӨРИЙН АЛБАНЫ МЭРГЭШЛИЙН
ШАЛГАЛТЫН ТУХАЙ**

Нэг. Мэргэшлийн шалгалтын зорилго

Завхан аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог анх орох иргэдээс өрсөлдүүлэн шалгаруулж нөхөхөд төрийн албаны мэргэшлийн шалгалтын зорилго оршино.

Хоёр. Мэргэшлийн шалгалтын бүртгэл, зардал

Зарлагдаж буй сул орон тоонд тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар болон тусгай шаардлагыг хангасан, энэ албан тушаалд ажиллахыг хүссэн иргэнийг бүртгэнэ.

Тус аймгийн нутгийн захиргааны байгууллагаас зарласан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх иргэнийг сонгон шалгаруулах мэргэшлийн шалгалтад орохыг хүссэн иргэдийг Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар дээр **2018 оны 12 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд 10.00-17.00** цагийн хооронд бүртгэнэ.

Мэргэшлийн шалгалтад орох иргэн шалгалттай холбогдох зардлыг өөрөө хариуцах бөгөөд мэргэшлийн шалгалт өгөх иргэний шалгалтын үйлчилгээний зардал **6000** төгрөг байна.

Гурав. Бүртгүүлэх иргэн дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ

Төрийн албан хаагчийн анкет (Төрийн албан хаагчийн анкетыг маягт N1-ийн дагуу бүрэн бөглөсөн байх);

Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн эхийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт;

Мэргэшүүлэх сургалтанд хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн эх хувийг хуулбарын хамт;

Иргэний үнэмлэхний эх, хуулбарын хамт;

“4 х 6”-гийн хэмжээний цээж зураг 2 хувь;

Ажилласан хугацаа болон ажил эрхлэлтийг гэрчлэх баримт /Нийгмийн даатгал, хөдөлмөрийн дэвтэр/-ийн эх хувийг хуулбарын хамт

Шалгалтын үйлчилгээний төлбөр

Дөрөв. Шалгалтын хуваарь

2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр шалгалтыг доорхи байдлаар зохион байгуулна.

1. Ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох шалгалт

2. Ур чадварын түвшин тогтоох шалгалт /Ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох шалгалтад тэнцсэн иргэн өгнө/

3. Мэдлэг, хандлага, зан үйлийг тодорхойлох шалгалт /Ур чадварын түвшин тогтоох шалгалтад тэнцсэн иргэн өгнө/

Шалгалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам, заавар”-тай танилцаж, авна уу.

Шалгалт авах газар, хуваарийг бүртгүүлсэн иргэдийн тооноос хамааруулан **2018 оны 10 дугаар сарын 13 -ны өдрийн 16.00** цагт Засаг даргын Тамгын газар дээр мэдээлнэ.

Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгөх иргэд **Иргэний үнэмлэхтэйгээ** ирнэ.

Тав. Мэдээлэл лавлагаа

Мэргэшлийн шалгалттай холбоотой асуудлаар тус аймгийн ЗДТГ-ын 70462801, 98826166 дугаарын утсаар холбогдож лавлагаа авч болно.

Шалгалт өгөх иргэдийн анхааралд:

1990 оны 05 дугаар сарын 06-ны өдөр болон түүнээс хойш төрсөн иргэн хуульд заасан цэргийн жинхэнэ алба хаах үүргээ биелүүлээгүй бол төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад оруулахгүй.

ЗАВХАН АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛЫН СУЛ ОРОН ТОО БОЛОН АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Д/Д	Захиалга өгсөн байгууллага	Нэгжийн нэр	Албан тушаалын				Ажлын байранд тавигдах шаардлага					
			Ангилал	Нэр	Хариуцсан асуудал	Орон тоо	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага	Ур чадвар	Тусгай шаардлага
ДЭС ТҮШМЭЛ												
1	Нийгмийн Даатгалын хэлтэс	Нийгмийн Даатгалын хэлтэс	ТЗ-5	Дөрвөлжин сум дахь Нийгмийн даатгалын байцаагч	Нийгмийн даатгал	1	Дээд боловсролын “Бакалавр” болон түүнээс дээш зэрэгтэй байх	Нягтлан бодогч, санхүүч, Эдийн засагч	Тухайн мэргэжлээр мэргэшсэн байх	Төрийн албанд ажилласан туршлагатай байх	Оффис хэрэглээний программ, тоног төхөөрөмж ашиглах чадвартай, бүтээлч, санаачлагатай байх, үйлчлүүлэгчидтэй эелдэг, нээлттэй харилцах, өөрчлөлтийг хэрэгжүүлэх	Төрийн албан хаагчийн болон Шүүхийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй сахих, нууц хадгалах, зөв харилцаа, хандлагатай байх, ажлын ачаалал даах чадвартай
2	Нийгмийн Даатгалын хэлтэс	Нийгмийн Даатгалын хэлтэс	ТЗ-5	Цагаанчулуут сум дахь Нийгмийн даатгалын байцаагч	Нийгмийн даатгал	1	Дээд боловсролын “Бакалавр” болон түүнээс дээш зэрэгтэй байх	Нягтлан бодогч, санхүүч, Эдийн засагч	Тухайн мэргэжлээр мэргэшсэн байх	Төрийн албанд ажилласан туршлагатай байх	Оффис хэрэглээний программ, тоног төхөөрөмж ашиглах чадвартай, бүтээлч, санаачлагатай байх, үйлчлүүлэгчидтэй эелдэг, нээлттэй харилцах, өөрчлөлтийг хэрэгжүүлэх	Шаардлагатай тохиолдолд илүү цагаар ажиллах

3	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	T3-5	Завханмандал сум дахь Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Хөдөлмөр эрхлэлт, халамж	1	Дээд боловсролын “Бакалавр” болон түүнээс дээш зэрэгтэй байх	Нийгмийн ажилтан, эрх зүйч, нягтлан бодогч, эдийн засагч, багш	Нийгмийн ажилтны чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан байх	Төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх	Ажлын ачаалал даах чадвартай, программын мэдээллийг олгогдсон эрх хэмжээнд ашиглаж, нууцлалыг хадгалах	Шаардлагатай тохиолдолд илүү цагаар ажиллах
4	Боловсрол соёл урлагийн газар	Боловсрол соёл урлагийн газар	T3-5	Хими, биологи, эрүүл мэндийн боловсрол хариуцсан мэргэжилтэн	Хими, биологи, эрүүл мэндийн боловсрол	1	Бакалавр болон түүнээс дээш боловсролтой	Хими, биологи, эрүүл мэндийн багш	Хими, биологи, эрүүл мэнд	ЕБС-д 5-аас дээш жил багшаар ажилласан байх	Удирдан зохион байгуулах чадвартай, харилцааны соёлтой, багаар ажиллах чадвартай, албан хэрэг хөтлөх, албан бичиг боловсруулах чадвартай гадаад хэлний зохих мэдлэгтэй байх	
5	Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа	Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах нэгж	T3-5	Газрын доорх усны нөөц, хяналт, шинжилгээ хариуцсан мэргэжилтэн	Усны тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сав газрын УННМ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, сав газрын хэмжээнд газрын доорх устай холбоотой	1	Геологийн бакалавраас дээш боловсролтой	Гидрогеологич инженер	Усны менежмент	Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажилласан	Компьютерийн хэрэглээний программ дээр ажиллах чадвартай, англи хэлний зохих мэдлэгтэй, Асуудал шийдвэрлэх, боловсруулах, зохион байгуулах, багаар	

					тооцоо, судалгаа хийх, усны нөөц ашиглалтын балансыг тооцох						ажиллах, бусдыг манлайлах чадвартай	
6	Эрүүл мэндийн газар	Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс	T3-5	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эрсдэл, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эрсдэл, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал	1	Анагаах ухааны бакалавр болон түүнээс дээш боловсролтой	Хүний их эмч	Эрүүл мэндийн удирдлага тусламж үйлчилгээний чанарын чиглэлээр сургалтанд хамрагдсан	Клиникт мэргэжлээрээ 1-с доошгүй жил ажилласан	Компьютерийн хэрэглээний программ дээр ажиллах чадвартай, Англи хэлний зохих мэдлэгтэй, Албан бичиг боловсруулах, багаар ажиллах чадвартай, мэргэжлээрээ мэргэшсэн	Оюун санаа бие бялдрын хувьд эрүүл байх, Хууль журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахидаг, Нууц хадгалах чадвартай, идэвхи санаачилгатай, харилцааны өндөр соёлтой, багаар ажиллах чадвартай байх
7	Эрүүл мэндийн газар	Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтэс	T3-5	Эрүүл мэндийн мэдээний сан хариуцсан мэргэжилтэн	Эрүүл мэндийн статистикийн мэдээ мэдээллийн асуудал	1	Анагаах ухааны бакалавр болон түүнээс дээш боловсролтой	Хүний их, бага эмч, Эрүүл мэндийн мэдээлэл зүйч	Эрүүл мэндийн статистикийн чиглэлээр мэргэшсэн	Мэргэжлээрээ ажилласан байх	Компьютерийн хэрэглээний програм дээр ажиллах чадвартай, Англи хэлний зохих мэдлэгтэй, Албан бичиг боловсруулах, багаар ажиллах чадвартай, мэргэжлээрээ мэргэшсэн	Оюун санаа бие бялдрын хувьд эрүүл байх, Хууль журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахидаг, Нууц хадгалах чадвартай, идэвхи санаачилгатай, харилцааны өндөр соёлтой, багаар ажиллах чадвартай байх
8	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Аялал жуулчлалын алба	T3-5	Байгалийн гамшиг, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	Байгалийн гамшиг, сургалт сурталчилгаа	1	бакалавр болон түүнээс дээш боловсролтой	Байгаль орчны болон эдийн засгийн чиглэлээр мэргэжилтэй байх	Компьютерийн өргөн хэрэглээний программ эзэмшсэн байх	Мэргэжлээрээ 1 хүртэлх жил ажилласан байх	Төрийн удирдлагын болон хууль эрх зүй, эдийн засгийн өргөн мэдлэгтэй, бодлого	Харилцааны соёлтой, орчноо мэдрэх, зөв үнэлэх, олон нийттэй харилцах чадвартай байх, Бийеийн эрүүл мэнд сайн, илүү цагаар болон ачаалал ихтэй ажиллах

										боловсруулах асуудалд дүгнэлт гаргах чадвартай, гадаад хэл, компьютерийн өргөн хэрэглээний программ эзэмшсэн байх, багаар ажиллах, манлайлах, бусдад нөлөөлөх, чадвартай байх	бололцоотой байх, Хууль дээдлэн, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах	
9	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Үйлдвэр худалдаа үйлчилгээний алба	T3-5	Хүнсний үйлдвэрлэл, технологи, худалдаа, нийтийн хоолны асуудал хариуцсан мэргэжилтэн	Хүнсний үйлдвэрлэл, технологи, худалдаа, нийтийн хоолны асуудал	1	бакалавр болон түүнээс дээш боловсролтой	Хүнс, хүнсний үйлдвэрлэлийн технологич, нийтийн хоолны технологич, эрүүл ахуйч	Дипломын дараах сургалтанд хамрагдсан байх, Хүнс судлаач	Хүнс, нийтийн хоолны чиглэлээр ажилласан байх, Төрийн албанд 2-оос доошгүй жил ажилласан байх	Ажлаа танилцуулж, өөрийгөө илэрхийлэх болон зохион байгуулах, тайлан мэдээ, танилцуулга нэгтгэн боловсруулах дүн шинжилгээ хийх чадвартай байх, баримт бичиг боловсруулж асуудлыг шийдвэрлүүлэх, багаар ажиллах, хариуцлага хүлээх чадвартай байх,	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, Үнэнч, шударга боловсон байдлыг эрхэмлэдэг, харилцааны соёлтой, байгууллага болон хувь хүний нууцыг хадгалах чадвартай, шаардлагатай үед илүү цагаар ажиллах

											Монгол хэл бичиг, хууль эрх зүйн мэдлэгтэй, компьютерийн өргөн хэрэглээний программууд дээр ажиллах, шийдвэр гаргаж, үр дүнг тооцож ажиллах чадвартай байх	
10	Тарвагатайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа		T3-5	Аялал жуучлал, мэдээлэл сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	Аялал жуучлал, мэдээлэл сурталчилгаа	1	бакалавр болон түүнээс дээш боловсролтой	Аялал жуучлал, байгаль орчин	Төрийн удирдлага	Төрийн албанд 3-аас доошгүй, мэргэжлээрээ 1-ээс доошгүй ажил ажилласан	Мэргэжлийн англи хэлтэй, Компьютерийн өргөн хэрэглээний программ болон цахим шуудан, интернет программ дээр ажиллах чадвартай байх	Багаар ажиллах, асуудал боловсруулах, илтгэх, цаашид ахиж дэвших чадвартай байх
11	Цагаанхайрхан сум	Цагаанхайрхан сумын Засаг даргын Тамгын газар	T3-6	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	Байгаль орчин	1	бакалавр болон түүнээс дээш боловсролтой	Байгаль орчны салбарын болон багш мэргэжилтэй байх	Байгаль орчны хамгаалал	Төрийн албанд ажилласан туршлагатай байх	Багаар ажиллах, харилцааны үр чадвартай зохион байгуулах, асуудал боловсруулах, шийдвэр гаргах, хүнтэй ажиллах арга	Эрх мэдлийнхээ хүрээнд бусдад нөлөөлөх чадвартай, орчноо мэдэрч зөв үнэлэх, мэдлэгтэй байх, хүнтэй зөв харилцах, удирдан зохион байгуулах, асуудал шийдвэрлэх үр чадвартай байх Компьютерийн хэрэглээний программ дээр ажиллах чадвартай,

											барилтай	төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих
12	Цагаанчулуут сум	Цагаанчулуут сумын Засаг даргын Тамгын газар	T3-6	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	Байгаль орчин	1	Дээд боловсролтой	Байгаль орчны болон бусад	Төрийн удирдлага, эрх зүйн чиглэлээр мэргэшсэн байх	Төрийн албанд 1 жил, мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажилласан байх	Багаар ажиллах чадвартай, шударга, харилцааны соёлтой, Компьютерийн хэрэглээний программуд болон интернет орчинд чөлөөтэй ажилладаг	Орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах боломжтой
13	Нөмрөг сум	Нөмрөг сумын Засаг даргын Тамгын газар	T3-6	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	Байгаль орчин	1	Дээд боловсролтой	Химич, байгаль хамгаалагч, экологич, ан агнуур зүйч, ургамал судлаач	Тухайн мэргэжлээр мэргэшсэн байх	Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх	Багаар ажиллах чадвартай, шударга, харилцааны соёлтой, Компьютерийн хэрэглээний программуд болон интернет орчинд чөлөөтэй ажилладаг	Орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах боломжтой
14	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	Газрын удирдлагын хэлтэс	T3-5	Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг гаргах, тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хангуулах,	1	бакалавр болон түүнээс дээш боловсролтой	Хуульч, эрх зүйч	Захиргаа, иргэний эрх зүйгээр мэргэшсэн байх	Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх	Асуудал дэвшүүлэх, журам, заавар, аргачлалыг хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх ажлыг зохион	Хууль журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахидаг, Нууц хадгалах чадвартай, идэвхи санаачилгатай, харилцааны өндөр соёлтой, багаар ажиллах чадвартай

					салбарын хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журам зааврыг орон нутагт хэрэгжүүлэх, иргэн аж ахуйн нэгж байгууллагатай байгуулах гэрээний төслийг боловсруулж, хууль журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, эрх зүйн үндэслэлийг хангуулах					байгуулах Компьютерийн хэрэглээний програм дээр ажиллах чадвартай, Англи хэлний зохих мэдлэгтэй,	байх	
15	Статистикийн хэлтэс	Статистикийн хэлтэс	T3-5	Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээ, хил гааль, сүм хийд, аж үйлдвэрийн салбар хариуцсан мэргэжилтэн	Статистикийн үйл ажиллагааг эрхлэх, статистикийн бодит судалгаа, үнэн зөв мэдээллээр иргэн хуулийн этгээдэд үйлчлэх, сумын статистикийн ажилтан, албан хаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх асуудал	1	бакалавр болон түүнээс дээш боловсролтой	Эдийн засагч, статистикч, нягтлан бодогч, санхүүч, хүн ам зүйч	Тухайн мэргэжлээр мэргэшсэн байх	Мэргэжлээрээ 2,5-аас дээш ажилласан, Судалгаа, Шинжилгээний ажил хийж байсан	Компьютер дээр ажиллах өргөн хүрээний мэдлэгтэй, бичиг баримт боловсруулах, харилцааны өндөр соёлтой, багаар ажиллах чадвартай	Орчноо мэдрэх, зөв үнэлдэг, төрийн захиргааны ажилтны ёс зүйн хэм хэмжээний дүрмийн шаардлагыг хангасан
16	Улиастай сумын Засаг даргын Тамгын газар	Захирагчийн ажлын алба	T3-4	Дэд бүтэц хариуцсан түшмэл	Эрчим хүч, дулаан, цэвэр бохир усны хангамж, барилга, авто зам тээвэр, холбоо	1	бакалавр болон түүнээс дээш боловсролтой	Иргэний байгууллагын барилгын инженер	Барилгын инженер	Мэргэжлээрээ 4-өөс доошгүй жил, төрийн албанд 1-ээс доошгүй жил ажилласан байх	Компьютерийн хэрэглээний программуудыг бүрэн эзэмшсэн, багаар ажиллах	Автокад, барилгын зураг төсөл боловсруулах программ болон хот байгуулалт, төлөвлөлтийн программ дээр ажиллах чадвартай

											чадвартай байх	байх
17	Улиастай сумын Засаг даргын Тамгын газар	Захирагчийн ажлын алба	T3-4	Архитектор	Газар зохион байгуулалт, хот байгуулалт, төлөвлөлт	1	бакалавр болон түүнээс дээш боловсролтой	Архитектор ч	Архитектор	Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх	Компьютерийн хэрэглээний программуудыг бүрэн эзэмшсэн, багаар ажиллах чадвартай байх	Автокад, 3D max программ дээр ажиллах чадвартай
18	Улиастай сумын Засаг даргын Тамгын газар	Захирагчийн ажлын алба	T3-4	Газар тариалан хариуцсан түшмэл	Газар тариалан эрхлэгчдийг мэдээллээр хангах, заавар зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах	1	бакалавр болон түүнээс дээш боловсролтой	Агрономич	Агрономич	Мэргэжлээрээ 2-оос доошгүй, төрийн албанд 1-ээс доошгүй жил ажилласан байх	Компьютерийн хэрэглээний программуудыг бүрэн эзэмшсэн, багаар ажиллах, зөвлөн туслах чадвартай байх	Хүнсний болон бусад нарийн ногоо тариалалтын мэдлэг сайтай бай

ТӨРИЙН АЛБАНЫ МЭРГЭШЛИЙН ШАЛГАЛТЫН ТӨВ КОМИСС

